



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН  
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2021.01.26 № 1а/413  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн  
хэм хэмжээг чанд мөрдөн  
ажиллах тухай


Монгол улсад коронавируст халдвар /КОВИД-19/ голомтлон гарч байгаа өнөө үед эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд бид бүхэн уг халдварыг хүн амын дунд тархахаас сэргийлэн тандаж, эмчлэн эдгэрүүлэхэд чармайн ажиллаж байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “хүмүүнлэг, энэрэнгүй ёс .... тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх”, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.4 дэх хэсэгт “Хүнлэг, энэрэнгүй байх, хүндэтгэлтэй хандах, хүн бүрт тэгш хандаж ...” гэж үйлчлүүлэгч болон эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага, ёс суртахууны хэм хэмжээг хуульчилсан байдаг.

Гэвч зарим эрүүл мэндийн байгууллагын цөөн тооны эмч, ажилтан тухайлбал Халдварт өвчин судлалын үндэсний төв болон нийслэлийн Өргөө амаржих газрын ажилтан нь өвчтөн шилжүүлэх явцдаа хайхрамжгүй, хариуцлагагүй хандсан нь эрүүл мэндийн салбарын олон мянган эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны нөр их хөдөлмөр, нэр хүндийг сэвтүүлж, иргэдийг ихээхэн бухимдуулж улмаар нийгмийн сэтгэл зүйд ч сөргөөр нөлөөллөө.

Иймд иргэдэд эрүүл мэндийн аливаа тусламжийг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэн, хүн ёсны харилцааны наад захын хэм хэмжээ, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, стандарт, хуулийн заалтыг чанд мөрдөн, хариуцлагатай ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, нийт эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилчдад анхааруулж байна.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.МӨНХСАЙХАН

144211133